



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТАМГЫН
ГАЗАР

Ж.Самбуугийн гудамж 18, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар
хот 15170.

Утас: 51-261544 Факс: 11-320622

Цахим шуудан: info@supremecourt.mn

Цахим хуудас: <https://www.supremecourt.mn>

2024.07.06 № 05/4044

танай _____-ны № _____-т

Тендер шалгаруулалтыг
үргэлжлүүлэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газраас зарласан УДШ/20240210203009 дугаартай “Даатгалын үйлчилгээ” төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг сонирхогч этгээдээс гомдол гарсантай холбогдуулан түр түдгэлзүүлсэн.

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 01/1258 дугаар “Тендерийн баримт бичиг хянасан тухай” албан мэдэгдлээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална” гэж зааснаар тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 18.2-т “Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг, 2024 оны 1-р улирлын байдлаар төлбөрийн чадвар 110%-аас дээш байна” гэж заасан байсныг Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 559 дүгээр тогтоолоор баталсан “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих” журмын 2.19-д заасан шалгуур үзүүлэлт болгон өөрчлөн үргэлжлүүлэн явуулахыг даалгасан байна.

Иймд Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газраас зарласан УДШ/20240210203009 дугаартай “Даатгалын үйлчилгээ” төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг баримт бичгийн тендер хүлээн авах эцсийн хугацаа болон тендер нээх хугацааг өөрчлөн үргэлжлүүлж байгааг үүгээр мэдэгдэж байна.



УЛСЫН ДЭЭД ШҮҮХ
ТАМГЫН ГАЗАР
ДАРГА
СОДНОМЦЭРЭН ЗАЯАДЭЛГЭР
2024-07-05 17:31:04